



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 8/24

Улаанбаатар хот


Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Ажлын албаны данс бүртгэлд хөрөнгө
бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн өтгөэдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 590,000.0 /таван зуун ерэн мянган/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /М.Давааням/-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг авахыг Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /М.Давааням/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-д даалгасугай.



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2020 оны 02..дугаар
сарын 11..өдрийн 08:00 тоот тушаалын хавсралт



Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт, хүчин чадал	Ашиглалтад авсан отноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ		Хандивлагч байгууллага	
								Нэгжийн үнэ	Нийт дүн	Нэр	Эх үүсвэр
	Тавилга, эд хогшил										
1	Оффис сандал	Дугуйтай хар	Эргэдэг	2019	шинэ	ш	6	75,000	450,000	Иргэд	Хандив
2	Сэтгүүлийн ширээ	Хүрэн	Модон	2019	шинэ	ш	1	140,000	140,000		
Тавилга, эд хогшлын дүн							7		590,000		